

Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтэс
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
3.1.	Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа болон гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих	-	-	-	-	-	Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны нэгдсэн бодлого, зохицуулалтыг хангах зорилтын хүрээнд хоёр болон олон талт хэлэлцээрийн төслийг боловсруулж, тохиролцох, батлуулах бэлтгэлийг ханган ажиллаж, ЕАЭЗХ-тай Худалдааны түр хэлэлцээрийг Засгийн газар, УИХ-аар амжилттай хэлэлцүүлэн соёрхон батлууллаа. Мөн	100%	100%

							АХБ болон бусад түнш орнуудтай хамтын ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг уялдуулан тохиролцож, Эдийн засгийн коридорын хэрэгжилтэд		
							хяналт тавих механизмыг бэхжүүлж, Ажлын хэсгийг шинэчлэн байгуулснаар худалдаа, эдийн засгийн бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааны үр нөлөө мэдэгдэхүйц сайжрав.		
3.1.1	Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, холбогдох гэрээ,	Үйл ажиллагааны зардлаар	Хэрэгжилтийн явц /Хувь/	Хоёр талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх хүрээнд нийт 5 хамтын ажиллагааны баримт бичиг байгуулсан. Нийт 22 хэлэлцээрийн төсөл, 26 ярианы сэдэвт санал боловсруулж,	-	Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	2025 онд Монгол Улсын Засгийн газрын гадаад эдийн засгийн түншлэл, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлогын хүрээнд дараах гол баримт бичгүүдийг боловсруулж, бэлэн байдлыг ханган ажиллав.	100%	100%

	<p>хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хамтран ажиллах, хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авна.</p>			<p>холбогдох чиг үүргийн яамдад хүргүүлсэн.</p>			<p>Үүнд: -"Монгол, Оросын бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх 2026–2030 оны дунд хугацааны хөтөлбөр"-ийн төсөл; -"Эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Туркменистан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"; - "Худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын салбарт 2026–2028 онд хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай Засгийн газар хоорондын дунд хугацааны хөтөлбөр"; -Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яам болон Узбекистан Улсын Хөрөнгө оруулалт, аж үйлдвэр, худалдааны яам хоорондын хамтын ажиллагааны санамж бичгийн төсөл; -"Монгол</p>		
--	--	--	--	---	--	--	--	--	--

							Улс, Азийн хөгжлийн банкны Түншлэлийн стратеги”, -АХБ-тай байгуулах “Бодлого төлөвлөлт, бизнесийн орчны чиглэлийн техникийн туслалцааны төслийн санамж бичиг”-ийн төсөл.		
3.1.2	Худалдаа, эдийн засаг, санхүүгийн асуудлаар түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч салбар хоорондын уялдааг хангана.	Үйл ажиллагааны зардлаар	Хэрэгжилтийн явц /Хувь/	Өндөр, дээд түвшний нийт 45 уулзалт, ТНБД, газрын дарга нарын түвшинд 59 уулзалт зохион байгуулсан. Түнш улс орон, олон улсын байгууллагатай хөгжүүлсэн харилцаа, хамтын ажиллагааны мэдээллийн сан, бүрдүүлэн тухай бүр шинэчилж ашигласан.	-	Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	Монгол Улс–АХБ-тай 2025–2028 онд хамтран ажиллах салбар, чиглэл, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тохиролцох бэлтгэл ажлыг ханган ажиллав. Үүний хүрээнд салбар байгууллагуудаас ирүүлсэн АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн саналуудыг нэгтгэн эрэмбэлж, зээл, тусламж, техник туслалцааны төсөлтэй холбогдох асуудлаар нийт 16 уулзалт, ЭЗХЯ-ны чадавхыг бэхжүүлэх техник	100%	90%

							туслалцааны хэрэгжилт болон шинээр хэрэгжүүлэх бүрэлдэхүүн хэсгийг хэлэлцсэн 12 уулзалт зохион байгуулж, уялдааг ханган ажиллав. Мөн БНХАУ, ОХУ, Австрали, Узбекистан, Азербайжан зэрэг хоёр талт түншүүдтэй хэрэгжүүлэх арга хэмжээг уялдуулах чиглэлээр нийт 20 уулзалтыг зохион байгуулснаар хамтын ажиллагааны бодит үйл ажиллагаа өргөжиж, салбар хоорондын уялдаа зохион байгуулалт сайжрав.		
3.1.3	Эдийн засгийн коридорын төсөл хөтөлбөрүүдийг тохиролцох, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	Үйл ажиллагааны зардлаар	Хэрэгжилтийн явц /Хувь/	ЭЗК-ын хөтөлбөрийг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулах тухай 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 01/2220 тоот	-	Төсөл, арга хэмжээнүүд холбогдох баримт бичгүүдтэй уялдан эрэмбэлэгдэж, хэрэгжилт нь хангагдсан байна. /100	Монгол–Орос–Хятадын Эдийн засгийн коридорын хүрээнд төслүүдийн уялдаа, хэрэгжилтэд хяналт тавих зорилтын дагуу шинжээчдийн	100%	100%

				албан бичгийг холбогдох яамдад хүргүүлсэн.		хувь/	хурлыг зохион байгуулж, хэлэлцсэн асуудлын протокол болон Монголын талын саналуудыг нэгтгэн ОХУ, БНХАУ-ын талуудад дипломат шугамаар хүргүүлж, албажуулах үйл ажиллагааг эхлүүллээ. Түүнчлэн холбогдох орчуулга, дүн шинжилгээ, мэдээллийг ГХЯ- ны Хөрш орнуудын газарт цахим хэлбэрээр хүргүүлж, хэрэгжилтийн явцыг тасралтгүй мэдээллээр ханган ажиллав. Мөн Монголын талын оролцоог сайжруулах, зохион байгуулалтын уялдааг бэхжүүлэх зорилгоор Эдийн засгийн коридорын Ажлын хэсгийг шинэчлэх саналыг ЗГХЭГ-т уламжилж, үүний		
--	--	--	--	---	--	-------	---	--	--

							үр дүнд Ерөнхий сайдын 2025 оны 133 дугаар захирамжаар шинэ бүрэлдэхүүнийг батлуулсан.		
3.1.4	Эдийн засаг, худалдааны чиглэлээр байгуулсан олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авах, хэрэгжилтэд хяналт тавина.	Үйл ажиллагааны зардлаар	Хэрэгжилтийн явц /Хувь/	Монгол Улс нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн ба Ази-номхон далайн худалдааны хэлэлцээр, Ази-номхон далайн хил дамнансан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр, Европын холбооны хөнгөлөлтийн ерөнхий системд тус тус нэгдэн орсон байх ба Япон улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан.	-	Тухай бүр судалгаа хийн дүгнэлт гаргаж, санал боловсруулан, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	Эдийн засаг, худалдааны чиглэлээр байгуулагдсан хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн үр ашгийг сайжруулах зорилтын хүрээнд Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ) болон түүний гишүүн орнуудтай байгуулах Худалдааны түр хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн, Улсын Их Хуралд өргөн барьж соёрхон батлууллаа. Ингэснээр Монгол Улс ЕАЭЗХ-ний гишүүн орнуудтай тариф, тарифын бус саадыг бууруулах, экспортын	100%	90%

27

								боломжийг нэмэгдүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж, хэлэлцээрийн хэрэгжилтийн цаашдын зохицуулалт, хяналтын механизмыг бэхжүүлэх нөхцөл хангагдав.		
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Үнэлсэн:

Төрийн нарийн бичгийн дарга
(албан тушаал)




.....
(гарын үсэг)


/М.Батхүү/

2025.12.15

(огноо)

Тайлагнасан:

Эдийн засгийн хамтын
ажиллагааны хэлтсийн дарга
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

/Б.Урьболд/

2025.12.15

(огноо)